



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/238

Булган сум

**“Эрүүл залуучууд-Ирээдүйн эзэд”
залуучуудын чуулган зохион байгуулах
ажлын хэсэг томилох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны IX/69 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Залуучуудын чуулган зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Д.Нарантуяа (Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

А.Гантөмөр (Байгаль орчны газрын дарга)

О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)

Б.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)

Т.Баярбат (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

Б.Мягмарсүрэн (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Урантөгс (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын мэргэжилтэн)

Э.Манлайбаатар (Булган аймгийн залуучуудын холбооны дарга)

Нарийн бичгийн дарга: Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

2. Үйл ажиллагааг чанартай, үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

